## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

**Бүсийн оношилгоо эмчилгээний төв** **2025 оны 12 дугаар сарын 01**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Үр нөлөө | Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | | |
| 16 | 33 | Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 | 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.) | Тайлант хугацаанд 2025 оны худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу 2025 онд 7,965,480.0 төгрөгний төсөвт өртөгтэй нийт 28 бараа, ажил үйлчилгээг бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлаар батлуулж худалдан авах ажиллагааны цахим систем tender.cov.mn сайтад байршуулсан. Үнээс шууд худалдан авалт 13, нээлттэй тендер 7, харьцуулалтын аргаар 5, ерөнхий гэрээгээр 3 тус тус нийтэлсэн. Нийтлэгдсэн тендерүүдээс нээлттэй тендерийг 72 багцад нийт 5 тендер зарлан шалгарсан компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Харьцуулалтын аргаар 4 тендер зарлан 3 тендер амжилттай болж шалгарсан компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Нийт 12 тендерийг худалдан авах ажиллагааны Tender.gov сайтад нийтлэх төлөвлөснөөс 10 тендер зарлагдсан ба өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн урсгал засварын тендерт компани орж ирээгүй. Мөн ХАНТ, Дүрс оношилгооны тасгуудын агааржуулалтын засварын ажил, нэн шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх тендерүүдийг ЭМДЕГ-аас Гүйцэтгэлийн санхүүжилтэд 2 удаа хязгаар тогтоосонтой холбоотойгоор зарлагдаагүй. Ерөнхий гэрээгээр худалдан авах барааг цахим дэлгүүрт байршуулан шалгарсан компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. | ЭТҮ-ний тасралтгүй хэвийн нөхцөл хангагдсан | ТБОНӨХБАҮ ХАТ хуулийн хүрээнд төлөвлөсөн Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө | 83.3 | |
| МУИХ-ын тогтоол | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 68 | | 6.в/. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудалтай холбоотой сэтгэцийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар зорилтот хөтөлбөр боловсруулах. (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:) | Тайлант хугацаанд нийт 579 үйлчлүүлэгч сэтгэцийн тусламж үйлчилгээнд хамрагдсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад орны фонд ашиглалт болон дундаж ор хоног буурсан үзүүлэлттэй. Нас баралт 1. Сэтгэцийн өвчлөлийн тэргүүлэх 5шалтгааныг судалж үзэхэд:<br>1. Архины шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг /F10/<br>2. Тэнэгрэл болон сэтгэцийн органик эмгэг /F.0/<br>3. Биеийн хэлбэрийн болон архаг мэдрэл сульдах /F45,F48/<br>4. Хурц солиорох болон шизофрени эмгэг /F20/<br>5. Оргaнтик бус нойргүйдэл /F50/ тус тус эзэлж байна.<br>Сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдээс нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдалт 55% буюу өмнөх оноос 3% -иар буурсан, нийт хэвтэн эмчлүүлэгч дотор хурц, нийгэмд аюултай үйлдэл хийх эмгэгээр хэвтэн эмчлүүлсэн тохиолдол 5% буюу 1.8 хувиар өссөн байна. | Сэтгэцийн тусламж үйлчилгээг эрсдэлгүй, аюулгүй, хүртээмжтэй үзүүлсэн | Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | 90 | |
| 34 | 73<br>74 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх | 3а/. ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга | Тайлант хугацаанд ахмадын кабинетаар нийт үзлэг 4,069, идэвхтэй хяналтад авсан 63.Гэрийн идэвхтэй үзлэг 21, дуудлагаар гэрийн үзлэг 6 ба нийт 139 ахмад хэвтэн эмчлүүлсэн байна. Ахмад настаны өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд<br>1. Шээс ялгаруулах тогтолцооны эмгэг<br>2. Зүрх судасны тогтолцооны эмгэг<br>3. Үе мөч, яс булчингийн тогтолцооны эмгэг<br>4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг<br>5. Хөгшрөл тус тус эзэлж байна. | Ахмад настаны идэвхитэй хяналт нэмэгдсэн | Ахмадын кабинетийн төлөвлөгөө | 70 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухаи 2023-05-04 Дугаар 2023 №35 | хэмжээг авч хэрэгжүүлэх; | | | | | |
| 35 | 75 | ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-05-04 Дугаар 2023_32 | 1.3. төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх. | БОЭТ-ийн дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажилладаг бөгөөд тайлант жилд 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээний төлөвлөгөө батлуулж 94.2% хэрэгжүүлж ажилласан. Үүнд:<br>- Тайлант хугацаанд 2025 онд Төрийн албан хаагчийн ёс зүйн салбар хороонд Чанарын албанаас шилжүүлсэн 2 гомдолыг хянан хэлэлцэж уг гомдол нь эмч иргэн хоёрын үл ойлголцолоос шалтгаалсан болохыг тогтоон иргэнтэй утсаар холбогдон эвлэрүүлэн зуучилсан.<br>- Нийт 8 удаа ёс зүйн сургалтыг зохион байгуулж 39 эмч, 122 сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад 13, үйлчлэгч 45, нийт 219 ажилтан хамрагдсан.<br>- ЭМС-ын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” А/406, 2023 оны “Сувилагч мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” ЭМС-ын А/319 дугаар тушаалуудаар нийт 3 удаа сургалт зохион байгуулж 5 эмч, 5 үйлчлэгч, 80 сувилагч, тусгай мэргэжилтэн,9 оюутан нийт 99 ажилтан хамрагдсан.<br>- “Еннеграм ба урлагын сэтгэл засал” сэтгэл зүйн сургалт, “Ажлын байранд тавигдах цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага, CS61—033:2020 стандарт, “Харилцаа хандлага, | Төрийн албан хаагчийн ёсзүй, харилцаа хандлагатай холбоотой гомдлын тоо буурсан | Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө | 94.2 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ёс суртхуун, биеэ авч явах соёл" Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас зохион байгуулсан "Сэтгэл зүйн зөвөлгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх" сургалт, Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хууль, "Орчин үеийн ёс зүй, харилцаа хандлага", "Ёс зүйн харилцаа хандлага, ажлын байран дахь стрессээс өөрийгөө хамгаалах нь" зэрэг 8 сэдвээр сургалт зохион байгуулсан ба нийт 30 удирдах ажилтан, 122 эмч, 168 сувилагч, тусгай мэргэжилтэн, 68 үйлчлэгч, нийт 388 ажилтан хамрагдсан | | | | |
| 36 | 76 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, чиглэлээр 5 зорилтын хүрээнд 12 ажил хийхээр төлөвлөсөн. Үүнд: Байгууллагын хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангаж дутагдалтай, сул ажлын байрны зарыг /www.orkhonboet.gov.mn сайт, "Мэдээллийн бирж", ЭМХТ-ийн төв /https://old.hdc.gov.mn/account s.php/, Эрүүл мэндийн газар"-ын сайтуудад 42 байршуулж ажилласан ба тайлант хугацаанд 19 их эмч 33 сувилагч, тусгай мэргэжилтэн, үйлчлэгч 8, бусад 11 нийт 69 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилтнаар томилогдсон байна. Мөн хүүхэд асрах чөлөөнөөс 31 ажилтан /11 их эмч, 2 эм зүйч, 16 сувилагч, тусгай мэргэжилтэн, 1 үйлчлэгч, бусад 1, /ажилдаа орсноор хүний нөөцийн тэнцвэртэй байдал хангагдахад эерэг нөлөө үзүүлсэн. Мөн "Ажилтан сонгон шалгаруулах журам"-ын (А/29) дагуу сул гарсан 4 ажлын байран дээр 6 удаа сонгон шалгаруулалтыг зарлаж (Хүний нөөцийн албаны дарга, санхүү бүртгэлийн албаны дарга, сургалтын албаны дарга, нягтлан бодогч, харуул, хоол зөөгч) нийт 6 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Шинээр томилогдсон 11 ажилтаны ХАСУМ-ыг хуулийн хугацаанд хянуулан томилуулж, 3 захирал, 7 албаны дарга, 25 тасгийн эрхлэгчийн "Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ийг цахим хэлбэрээр мэдүүлж, хянуулан баталгаажуулсан. Тайланд | Авлига, ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг сурталчилан ажилласан | Холбогдох хууль тогтоомж | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | хугацаанд "Төрийн албаны тухай хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" /MNS 7014 2023/" , "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт", ЭМЯ-наас "Дэлхийн эмч нарын баярын өдөр"-ийг угтаж зохион байгуулсан "Эмчээ сонсоё" цахим хэлэлцүүлэг, "Авилагаас ангид байх, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт" зэрэг 7 удаагийн сургалтанд 1340/давхардсан тоогоор/ ажилтан хамрагдсан. Тайлант хугацаанд иргэд, үйлчлүүлэгчээс нийт 119 хандалт ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хандалтын тохиолдлоор буурсан байна. Үүнд талархал 16, гомдол 36, санал хүсэлт 24 ирсэн байна. Өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл: Харьцаа хандлагатай холбоотой – 13, Эмнэлгийн тусламж үйлчилгээнд сэтгэл ханамжгүй – 12, цаг товлох үйлчилгээ, хүлээгдэл чирэгдэлтэй холбоотой – 6, Эмнэлгийн дотоод орчны тохижилт, зохион байгуулалт – 0, Эрүүл мэндийн даатгалын өөрчлөлттэй холбоотой - 2 Албан бус төлбөр- 2 агуулга бүхий өргөдөл гомдол байсныг тухай бүр судлан арга хэмжээ тооцон ажилласан | | | | |
| | 78 | | 1.8. өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог үргэлжлүүлэн эрчимжүүлж, хөдөөгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах; | Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 1963 иргэн хамрагдсанаас давхардсан тоогоор өвчлөлийн 4620 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс 1434 буюу 31% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин, 1293 буюу 28% нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 495 буюу 10.7% нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 1012 буюу 21.9% нь зүрх судасны тогтолцооны өвчин, 78 буюу 1.7% нь амьсгалын тогтолцооны өвчлөлүүд байна. Хавдрын 6 тохиолдол илэрсэн ба ходоодны хавдар 4 (C16), элэгний хавдар 1 (C22.0), Уушгины хавдар 1 ( 34.0) байв. Ходоодны эрт үеийн хавдартай 1 тохиолдолд | Орхон аймаг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдал таар улсад тэргүүлж ажилласан | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаал гарснаар ЭМС-ын 2023 оны А/379 дүгээр тушаал | 30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ходоодны салст хуулах мэс заслыг амжилттай хийсэн. Уушигны хавдартай 1 тохиолдол орон нутагтаа хими эмчилгээнд хамрагдаж байна. Бусад тохиолдлыг ХСҮТ-д илгээсэн. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг насны хувьд 18-30 нас 210, 31-45 нас 638, 46-60 нас 671, 61-с дээш 444 байна. | | хүчингүй болсон | | |
| | 79 | | 1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | Тайлант хугацаанд тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг хангах зорилгоор яаралтай тусламж, сэтгэц, сүрьеэгийн диспансерийн гадна авто зогсоолд тусгай хэрэгцээт иргэдийн автомашины тэмдэглэгээ бүхий зогсоолыг бий болгосон. Мөн тэргэнцэртэй иргэд давхар хооронд зорчих боломжийг бүрдүүлж орон нутгийн хөрөнгө оруулалтаар 43 сая төгрөгийн үнэ бүхий шатаар зөөвөрлөгч төхөөрөмжийг амбулаторийн тасагт байршуулж давхардсан тоогоор нийт 428 үйлчлүүлэгчийг зөөвөрлөсөн. Тус төхөөрөмжийг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 ,Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 , 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтын дагуу байгууллагын захирлын тушаалаар орлогод авч бүртгэсэн. | Тусгай хэрэгцээт иргэдийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн. | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон бусад эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө | 80 | |
| | | | УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 38 | 80 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын | 1.4. сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг | Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдвар 229 бүртгэгдсэн ба өмнөх оноос 68 тохиолдлоор нэмэгдсэн. Үүнээс 65 буюу 28.4% ийг тэмбүү, 25 буюу 10.9%-ийг заг хүйтэн, 61 буюу 26.6%-ийг трихомониаз тус тус эзэлж байна. Шинээр хяналтад хамрагдсан 518 жирэмсэн эмэгтэйн бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээний үзүүлэлтэд трихомониазын өвчлөл - 33, тэмбүүгийн өвчлөл - 9, заг хүйтний өвчлөл 1 гарч хавьталын хамт 100% | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчний илрүүлэг үзлэг нэмэгдсэн | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 80 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | МҮОНРТ, Боловсрол суваг болон бусад радио, телевиз, сонин хэвлэл, нийгмийн сүлжээг ашиглан хүн амын дунд зохион байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх; | эмчилгээнд хамрагдсан. Зорилтот бүлгийн 609 хүнээс ийлдсийн шинжилгээ авч, эерэг сорьц 51 илэрч, 4 шинэ өвчлөл илэрч, эмчилгээнд хамрагдсан. Сүрьеэгийн өвчлөл 77 тохиолдол бүртгэгдэж, 100000 хүн амд 72.7% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 35.1%-аар буурсан байна. Илрүүлэг шинжилгээнд нийт 1700 хүн хамрагдахаас 1700 /100%/ хамрагдаж, сэжигтэй 103 хүнд мантуугийн сорил тавьж, 5 хүнээс цэрний түрхэцийн шинжилгээ авсан. Сорил эерэг 62 хүнээс 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн эмчилгээ хяналтанд, 1 тохиолдлыг урьдчилан сэргийлэх эмчилгээ хяналтанд хамруулж, 8 тохиолдол хяналтанд, 50 тохиолдолыг онош тодруулах эмчилгээнд хамруулахаар ажиллаж байна. Сүрьеэгийн диспансерийн хяналтын эмчилгээний үр дүн: тайлангийн эхэнд хяналтад 38 хүн байсан ба 2025 онд шинээр хяналтад 71, дахилт 6, эмэнд тэсвэртэй 3, нийт 118 үйлчлүүлэгчийг хяналтанд авч 67 үйлчлүүлэгч хяналтаас гаргасан. Үүнээс эдгэрсэн 64, нас барсан 3, одоо хяналтад 51 өвчтөн эмчлэгдэж байгаагаас эмэнд мэдрэг сүрьеэ 49, эмэнд тэсвэртэй сүрьеэ 2 тохиолдол байна. Байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээлэлийн байгууллага, ЭМГ-ын пэйж хуудсуудаар дамжуулан Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн 58 мэдээлэлийг байгууллагын байршуулан нийт 16269 иргэнд хүргэсэн. | | | | |
| 48 | 98 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-10-19 Дугаар 2021 №05 | 7.. Хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн засаглалыг хагас бие даасан тогтолцоонд | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 06 өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр батламжлах тухай” Б/76 дугаар тушаалаар тус төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдхүүнийг Өмчлөгчийг төлөөлөх бүрэлдхүүнээр ЭМЯ, Сангийн яам, Эрүүл мэндийн даатгалын газрын төлөөлөл, тухайн эмнэлгийн хамт олны төлөөлөл 3, олон нийтийг төлөөлж төрийн бус байгууллагаас 2, мэргэжлийн салбар нийгэмлэгээс 1, нийт 9 гишүүнийг томилж ЭМС-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний А/543 дугаар тушаалаар "Төлөөлөн | Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна | Холбогдох хууль тогтоомжуудийн хүрээнд зохион байгуулллагдсан үйл ажиллагаа | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлүүдийг байгуулах ажлыг 2021 оны 12 дугаар сард багтаан дуусгах, Багануур, Баянгол, Налайх, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг нэгдсэн эмнэлэг болгож, хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх боломжийг бүрдүүлэх | удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг баталгаажуулсан. Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төлөөлөн удирдах зөвлөл нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын албан тушаалд сонгон шалгаруулалтыг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр нээлттэй зарлаж 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл зарласан ба тус сонгон шалгаруулалтад нэг оролцогч материал ирүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам” 414 дүгээр тушаалаар сонгон шалгаруулалтыг хийж тэнцсэн иргэний мэдээллийг АТГ-т хүргүүлэн ажиллаж байна. | | | | |
| | 101 | | 14.. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа программ хангамжуудыг нэгтгэж, нэн даруй нэгдсэн мэдээлэл солилцооны платформд шилжүүлэх, цахим хяналтыг сайжруулах | Бүсийн оношилгоо, эмчилгээнийтөв нь 2018–2025 онд МЕТЕХ ХХК-ийн Ehealth цахим хэрэглэгчийн программ хангамжийг ашиглаж байсан бөгөөд мэдээллийн солилцоо, цахим хяналтын үр ашиг, хөгжүүлэлтийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор программ хангамжийн шинэчлэл хийж 2025 оны 09-р сараас АКСИС ХХК-ийн “КАРТЕ” нэгдсэн цахим мэдээллийн программыг ашиглаж байна. Тус программ нь эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим систем, статистик мэдээний цахим программ, цахим үйлчилгээний нэгдсэн портал, төрийн мэдээлэл солилцооны системүүдтэй бүрэн холбогдсон бөгөөд байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | Мэдээлэл шуурхай солилцох нөхцөл бүрдэж гүйцэтгэлийн санхүүжилтийн хасагдлыг бууруулсан. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 102 | | 15.Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ил тод нээлттэй байдлыг хангах, хяналтыг сайжруулах | ТБОНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Tender.gov сайтад БОЭТ-н 2025 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулан хуулийн хүрээнд нээлттэй, харьцуулалтын, ерөнхий гэрээ, шууд гэрээний аргуудаар худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | Ил тод, нээлттэй байдлыг хангасан | Байгууллагын худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө | 100 | |
| 51 | 110 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.10. Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг (оношилгоо, эмчилгээний нэр төрөл, өрөө тасалгааны тоо хүртээмж, мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо) нэмэгдүүлэх; | Тайлант хугацаанд ахмадын кабинетаар нийт үзлэг 4,069, идэвхтэй хяналтад авсан 63.Гэрийн идэвхтэй үзлэг 21, дуудлагаар гэрийн үзлэг 6 ба нийт 139 ахмад хэвтэн эмчлүүлсэн байна. Ахмад настаны өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд<br>1. Шээс ялгаруулах тогтолцооны эмгэг<br>2. Зүрх судасны тогтолцооны эмгэг<br>3. Үе мөч, яс булчингийн тогтолцооны эмгэг<br>4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг<br>5. Хөгшрөл тус тус эзэлж байна. | Ахмад настаны идэвхитэй хяналт нэмэгдсэн | Ахмадын кабинетийн төлөвлөгөө | 70 | |
| 53 | 113 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022.06.15 №18 НББХ | 1.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, анагаах ухааны дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр эмнэлгүүдийг хангах замаар Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй байгаа | - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд 3,392,060,445 төгрөгний үнэ бүхий 144ш тоног төхөөрөмжөөр хангагдсан ба өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар нэмэгдсэн буюу 96%ийн хангалттай байна.<br>- Иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд “Үндэсний баг”-тай хамтран нийт 810 эмчийн үзлэг, хавдрын мэс засал 23, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ 131, ажилбар 17, хими эмчилгээ 49 хийсэн.Үүнд: Элэг тайрах мэс засал 7, ходоод тайрах мэс засал 2, хөхний хавдрын мэс засал 3, TACE 11. | Иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлсэн | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өвчнийг дотооддоо оношилж, эмчлэх боломжийг бүрдүүлэх; | БОЭТ-ийн эмч нар бие дааж элэг тайрах мэс засал 1, TACE 10, доод мөчдийн их өнгөц венийн судасыг сугалж авах мэс заслын 7 тохиолдлыг амжилттай хийсэн. Мөн үндэсний багтай хамтарч тархины судасны 14оношилгоо хийж аневризм 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол шинээр оношлогдсон ба орон нутагт хийгдэггүй зарим мэс заслыг нэвтрүүлж нутагшуулах зорилгоор ШУГТЭ, УХТЭ-т хүсэлт хүргүүлэн хамтын ажиллагааны хүрээнд гүрээний судасны бөглөрөл, нарийсалд стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг бие даан амжилттай хийсэн. | | | | |
| | 117 | | 1.5. Иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах | Байгууллагын цахим хуудас нь нийт 8701 дагагчтай бөгөөд тайлант хугацаанд иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх зорилгоор нийт 327 пост, 236 зураг, 68 видео, 64 рийл, 27текст, 16линк байршуулан 805,931 хандалт авсан. Иргэдийн хандалт өмнөх оны мөн үеэс 89,6%-р нэмэгдсэн байна. | Мэдээлэл сурталчилгааны хүртээмжтэй байдал хангагдсан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 80 | |
| | 128 | | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | Төсвийн төлөвлөлтийг хийхдээ барааны үнийн мэдээллийг татварын албанд хүргүүлсэн. "Цалин хөлсний бүтцийн судалгаа" судалгааны ажилд Монголын хөдөлмөрийн их сургууль, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтарсан судалгаанд оролцсон. | Холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа оролцоог хангасан | Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Улсын хэмжээнд 2 жил тутам явуулдаг судалгаа | 80 | |
| 58 | 131 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) | 1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн | БОЭТ-ийн дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажилладаг бөгөөд тайлант жилд 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээний төлөвлөгөө батлуулж 94.2% хэрэгжүүлж ажилласан. Үүнд: | Төрийн албан хаагчийн ёсзүй, харилцаа | Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө | 94.2 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-11-01 Дугаар 2023_10 | шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх; | - Тайлант хугацаанд 2025 онд Төрийн албан хаагчийн ёс зүйн салбар хороонд Чанарын албанаас шилжүүлсэн 2 гомдолыг хянан хэлэлцэж уг гомдол нь эмч иргэн хоёрын үл ойлголцолоос шалтгаалсан болохыг тогтоон иргэнтэй утсаар холбогдон эвлэрүүлэн зуучилсан.<br>- Нийт 8 удаа ёс зүйн сургалтыг зохион байгуулж 39 эмч, 122 сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад 13, үйлчлэгч 45, нийт 219 ажилтан хамрагдсан.<br>- ЭМС-ын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” А/406, 2023 оны “Сувилагч мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” ЭМС-ын А/319 дугаар тушаалуудаар нийт 3 удаа сургалт зохион байгуулж 5 эмч, 5 үйлчлэгч, 80 сувилагч, тусгай мэргэжилтэн,9 оюутан нийт 99 ажилтан хамрагдсан.<br>“Еннеграм ба урлагын сэтгэл засал” сэтгэл зүйн сургалт, “Ажлын байранд тавигдах цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага, CS61—033:2020 стандарт, “Харилцаа хандлага, ёс суртхуун, биеэ авч явах соёл” Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас зохион байгуулсан “Сэтгэл зүйн зөвөлгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх” сургалт, Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хууль, “Орчин үеийн ёс зүй, харилцаа хандлага”, “Ёс зүйн харилцаа хандлага, ажлын байран дахь стрессээс өөрийгөө хамгаалах нь” зэрэг 8 сэдвээр сургалт зохион байгуулсан ба нийт 30 удирдах ажилтан, 122 эмч, 168 сувилагч, тусгай мэргэжилтэн, 68 үйлчлэгч, нийт 388 ажилтан хамрагдсан | хандлагатай холбоотой гомдлын тоо буурсан | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | | |
| | 137 | | 1.13. Иргэдийн нас баралтад нөлөөлж байгаа өвчин эмгэгийн байдалд судалгаа хийж, өвчлөлийг бууруулах талаар зохион | 2025 оны эхний 11 сарын байдлаар эмнэлгийн нийт нас баралт 129 буюу өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор өссөн байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 1.4%-аар, үүн дотроо 8-24 цагийн доторх нас баралтын хувь 2.4-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Хүйсийн хувьд эрэгтэй 88, эмэгтэй 32. Насны хувьд:<br>- 0-1 нас 11 | Орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангасан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулалтын арга хэмжээ авч, санхүүжилтийг шийдвэрлэх. | - 1-14 нас 2<br>- 15-29 нас 1<br>- 30-49 нас 20<br>- 50-64 нас 53<br>- 65-аас дээш<br>Өвчний ангилалаар:<br>- Цусны эргэлтийн тогтолцооны өвчин -27<br>- Осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант 26<br>- Хавдар -21<br>- Хоол шингээх эрхтний өвчин 17<br>- Төрөх тойрны/перинатал/ үед үүссэн зарим эмгэг 8<br>- Амьсгалын тогтоцооны өвчин-7<br>- Дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчин -5<br>- Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 3<br>- Мэдрэлийн тогтолцооны өвчин – 2<br>- Арьс халимны өвчин 2<br>- Төрөлхийн гажиг 1<br>- Халдварт -1<br>Тайлант хугацаанд нас баралтын тэргүүлэх шалтгааны 3-рт эрэмбэлэгдэж буй Хорт хавдрын нас баралтад нөлөөлж буй шалтгаан, хүчин зүйлийг сүүлийн 10 жилийн байдлаар судалж үзэхэд хорт хавдрын өвчлөл, нас баралт жил бүр тогтмол өссөн. Хяналтад авсан иргэдийн тоо 10 жилийн өмнөхөөс 905 тохиолдлоор, шинээр оношлогдсон хорт хавдар 136 тохиолдлоор, нас баралт 55 тохиолдлоор тус тус өссөн үзүүлэлттэй. Өвчлөл, нас баралтын тэргүүлэх чиглэлд элэг, ходоод, уушиг, нойр булчирхайн хорт хавдар, сүүлийн жилүүдэд умайн хүзүү, хөх, тархины хавдар нэмэгдсэн байв. Нас, хүйсийн хувьд өвчлөл, нас баралтанд эрэгтэйчүүд илүү, насны ангиллаар авч үзвэл 50-аас дээш нас 80 хувь байна. Орхон аймгийн хорт хавдрын өвчлөл 10.000 хүн амд 30.6, аймгуудын дундаж 25.0, улсын дундаж 23.9, нас баралтын түвшин Орхон 17.9, аймгуудын дундаж 16.2, улсын дундаж 13.9 байгаа нь өвчлөл, нас баралтын түвшин улс, аймгийн дундажаас тус тус өндөр байна. Хорт хавдрын шалтгаант нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлд оношлогдож буй | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үе шат, хүн амын нас, амьдралын болон эрүүл мэндийн дадал хэвшил, хүн амын эрүүл мэндийн боловсрол дутмаг байдал зэрэг нь голлох шалтгаан болж байна. Хорт хавдрын шалтгаант өвчлөл, нас баралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замыг дараах байдлаар тодорйлсон. Үүнд:<br>- СӨБ болон ЕБС-ийн сургалтын программд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хичээлийг оруулах<br>- Хавдрын оношилгоо, эрт илрүүлгийг эрчимжүүлэх<br>- Хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлтэй дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх<br>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх<br>- Хүн амын дунд эрүүл хоололт, дасгал хөдөлгөөн, илүүдэл жин, таргалалтыг бууруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулж үр дүнг хэмждэг байх | | | | |
| 62 | 140 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Бүх нийтээр мод тарих Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд хавар намрын арга хэмжээнд идэвхтэй оролцож 3500 мод тарьсан. | Иргэний үндсэн үүргээ хэрэгжүүлсэн | Цаг үеийн арга хэмжээ | 100 | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | | |
| 70 | 157 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэ | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч | Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд үндэсний бичгийн сургалтыг долоо хоногт 2 удаа нийт 15 удаагийн хичээлээр унших, бичих дадлага хичээл орсон ба нийт 30 ажилтан хамрагдсан. Байгууллагын 122 | Хос бичигтэй болох арга хэмжээний бэлтгэл | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | х зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх | компьютерт Монгол бичгийн фонт суулган заавар аргазүйгээр хангасан. | хангагдаж байна | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | | | |
| 107 | 207 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | 3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, | Хүний нөөцийн бүртгэл судалгааг Төрийн албаны "ХНУМТ" цахим системээр хөтлөн явуулж байна. Тайлант хугацаанд нийт 554 ажилтан цахим системд бүрэн бүртгэгдсэнээс 357 хүний мэдээлэл бүрэн баталгаажсан байна. Холбогдох мэдээ тайланг Орхон аймгийн төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. | Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан | Засгийн газрын тогтоол | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | | | | | |
| 112 | 213 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | YIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; ("Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын | Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хорогдуулсан цагаар ажилладаг 87 ажилтан байна. Тус ажилчдад хуулийн дагуу цалин хөлсийг бүрэн олгон ажиллаж байна. | Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан | Засгийн газрын тогтоол | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гишүүдэд танилцуулав. ) | | | | | |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | |
| 125 | 229 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 | 2.6. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засахад шаардлагатай хүний нөөц, оношилгооны лаборатори, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах. | Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй, шинээр хяналтанд орсон 69 хүүхэд байна. БОЭТ-ийн Хүүхдийн тасагт тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй 52 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна.<br>9, 18, 36 сартайд хүүхдийн хөгжлийн хоцрогдолыг эрт илрүүлэх сургалтыг ЭМГ, БСУГ-тай хамтран 9 өрх, сумын 144 эмч сувилагч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдралын чанарыг дээшлүүлсэн | Нийгмийн халамжийн тухай хууль | 70 | |
| 126 | 231 | 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34 | XII.8.3. Улаанбаатар хотоос хөдөө рүү шилжин амьдрах асуудлыг дэмжих, орон нутагт амьдрахын давуу талыг сурталчлах, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг өрнүүлэх асуудлыг хамтран судалж, саналаа танилцуулахыг Хөдөлмөр, | Тайлант хугацаанд 2025 оны байдлаар нийт 23 ажилтан шинээр ажилд авсан ба үүнээс Улаанбаатар хотоос 8, 100% ажлын байраар хангана ажиллаж байна | Төвлөрлийг бууруулах бодлогыг дэмжиж ажилласан | Холбогдох хууль тогтоомж | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав. | | | | | |
| | 252 | | III.5. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд авлигыг таслан зогсоох, хүнд суртлыг арилгах чиглэлээр хариуцсан салбар бүрдээ тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Тайлант хугацаанд эмч эмнэлгийн ажилтнуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг нийт 2 удаа сурталчилан нийт 84 их эмч, 24 ахлах сувилагч хамрагдсан. Авлигын эсрэг хууль тогтоомжийг өөрийн байгууллагын цахим хуудсны “Хууль эрх зүйн” буланд байршуулсан ба АТГ-аас гаргасан сурталчилгааны хэвлэмэл материалуудыг Сургалт эрдэм шинжилгээний албаны мэдээлийн самбар, тасгийн тасаг нэгжүүдийн мэдээллийн самбарт байршуулсан. Мөн албан бус төлбөрийн талаар 151 үйлчүүлэгчийг хамруулсан судалгаа хийж үр дүнг нийт ажилтан, албан хаагч нарт танилцуулж зөвлөмж, сэрэмжлүүлэг, уриалга хүргэж ажилласан. | Авлига ашиг сонирхолоос ангид байх талаар тогтмол сурталчилж ажилласан | Авлигаас сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | 90 | |
| 145 | 270 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан | Тайлант хугацаанд “Хүний эрхийн үндэсний комисс”-оос 1 удаа хөндлөнгийн хяналт хийсэн. Хяналтаас эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, устгах талаар үүрэг, чиглэл ирүүлсэнийг хугацаанд нь хэрэгжүүлж хүргүүлсэн. Удирдлагын гаргасан шийдвэр, ажлын байрны орчин, нөхцөлд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчил илрээгүй. | Зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлж тайлагнасан | Хяналт үнэлгээний удирдамж | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | | | | | |
| 148 | 274 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын өөрийн цахим хуудсаар болон фэйсбүүк хуудсанд холбогдох мэдээллүүдийг тухай бүр байршуулсан.<br>Шилэн дансанд нийт 171 мэдээлэл оруулахаас хугацаандаа мэдээлсэн 138, хугацаа хоцорч мэдээлэлсэн 1, хугацаа болоогүй 32 байна. Байгууллагын цахим хуудсыг шинэчилсэн ба Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж хэвшсэн. | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 95 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | | | | | |
| | 303 | | XI.5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, | - Тайлант хугацаанд нийт ажиллагсдыг ажлын хувцсаар бүрэн хангасан хамгаалах хэрэгслийн хангалтын байдал | ХЭААБ -ыг ханган ажиллаж байна | Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө | 80 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбаруудад тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ажилтныг стандартад нийцсэн ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслээр хангах үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав | - Угааж ариутгах зориулалттай ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг 25 ажилтанд олгож шинэчилсэн.<br>- Нэг удаагийн хэрэгсэлд нийт 201,135,779.00 зарцуулсан.<br>- Аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Галын аюулгүй байдал”, “Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагаа” зэрэг сургалтуудад ажилчдыг үе шаттай хамруулсан. | | | | |
| 73 | 16 | Засгийн газрын 2024-2028 | 1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд | Аймгийн Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “ХИЧЭЭЛЛЭЕ- ӨРНҮҮЛЬЕ- ХЭВШЬЕ" аяны хүрээнд нийт 13 тасгийн 52 видеог | Хамтын ажиллагаа гаа | Цаг үеийн арга хэмжээ | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-03-07 Дугаар 2025-03 | идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх; | байгууллагын пэйж хуудас болон БТСГ-ын пэйж хуудсанд байршуулан сурталчилсан. Байгууллагын аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулж нийт 26 тасгийн 200 гаруй тамирчид амжилттай оролцсон. Диабеттай тэмцэх дэлхийн өдрийг тохи олдуулан эмчилгээний хоолны тасгаас чихрийн шижинтэй үйлчлүүлэгч нарт зориулан хоолны өдөрлөгийг зохион байгуулж 102 үйлчүүлэгч, асран хамгаалагч, тухайн өдөр эмнэлгээр үйлчлүүлж байсан үйлчлүүлэгч нарт эрүүл хоолны технологийг тусгасан гарын авлага түгээсэн | бэхжүүлсэн | | | |
| 344 | 23 | Улаан бурхан өвчний дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар ЭМС танилцуулав. 2025-04-23 Дугаар 19 | 2. Улаан бурхан өвчний тандалт дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ЭМС Т.Мөнхсайхан, аймаг нийслэлийн засаг дарга нарт даалгав | Улаанбурхан өвчний нөхцөл байдалд хийгдсэн эрсдэлийн үнэлгээ Өндөр эрсдэлтэй буюу улбар шар түвшинд үнэлэгдсэн ба хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж улаанбурханы сэжигтэй тохиолдол 108 бүртгэгдсэн. Үүнээс Лабораториор батлагдсан 41, эмнэлзүйгээр батлагдсан 27. Хэвтэн эмчлүүлсэн 59, гэрээр эмчлэгдсэн -9. Нас баралт, хүндрэл бүртгэгдээгүй. | Хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн. | Байгууллагын захирлын 2025 оны А/56 дугаар тушаалаар “Шуурхай удирдлагын баг”, А/57 дугаар тушаалаар “Эрсдэлийн үнэлгээний баг”-ийг тус тус томилсон | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 1963 иргэн хамрагдсанаас давхардсан тоогоор өвчлөлийн 4620 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс 1434 буюу 31% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин, 1293 буюу 28% нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 495 буюу 10.7% нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 1012 буюу 21.9% нь зүрх судасны тогтолцооны өвчин, 78 буюу 1.7% нь амьсгалын тогтолцооны өвчлөлүүд байна. Хавдрын 6 тохиолдол илэрсэн ба ходоодны хавдар 4 (С16), элэгний хавдар 1 (С22.0), Уушгины хавдар 1 ( 34.0) байв. Ходоодны эрт үеийн хавдартай 1 тохиолдолд ходоодны салст хуулах мэс заслыг амжилттай хийсэн. Уушигны хавдартай 1 тохиолдол орон нутагтаа хими эмчилгээнд хамрагдаж байна. Бусад тохиолдлыг ХСҮТ-д илгээсэн. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг насны хувьд 18-30 нас 210, 31-45 нас 638, 46-60 нас 671, 61-с дээш 444 байна. | Хорт хавдрын эрт илрүүлгийн хувь нэмэгдсэн | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | 30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 217 | | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 | “Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх үед хүн, хуулийн этгээдийг таньж, баталгаажуулахад ашиглах танилт, нэвтрэлтийн арга”-ыг ашиглах | Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа иргэдийн хурууны хээ, регистрийн дугаараар танин баталгаажуулж цахим систем хурдан системийг ашиглаж байна. | Хуулийн хэрэгжилт хангагдсан | Холбогдох хууль тогтоомж | 100 | |
| 204 | | Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 204 | 1.3.3 Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэх зорилгоор “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын харьяа “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг судлаж, шийдвэрлүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасугай. | - БОЭТ-д “Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв”-ийн засвар, тохижилтын ажилд нийт 350сая төгрөг батлагдсан. Засвар, тохижилтын ажлын гүйцэтгэл 100% .<br>- Тайлант хугацаанд тус төвөөр нийт 3502 үзлэг хийгдсэнээс өвчний учир эмнэлэгт хандан хавдар оношлогдсон 55 /27,2% / диспансерын хяналтад 219 иргэн байна. Нийт хавдрын 50,5 хувь нь эрт үедээ, 49,5 хувь нь хожуу үедээ оношлогдсон.Хими эмчилгээ 275, бай эмчилгээнд 138 хүн хамрагдсан байна.Тайлант хугацаанд 269 хавдрын шинэ тохиолдлыг оношлогдсон. Үүнээс 25.6%-ийг элэгний хорт хавдар,17.5%-ийг ходоодны хорт хавдар,7.4%-ийг умайн хүзүүний өмөн, 7%-ийг нойр булчирхайн хорт хавдар, 6.4%-ийг уушигны хорт хавдар, 5.6%-ийг бөөрний хорт хавдар, 4.5%-ийг улаан хоолойн хорт хавдар 4.1%-ийг хөхний хорт хавдар үлдсэн 21.9%-ийг бусад хавдар эзэлж байна.<br>- ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 773 сая төгрөгний үнэ бүхий 10 нэр төрлийн эмгэг судлалын чиглэлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан._ Тоног төхөөрөмжийн хангалт – 98% | Хойд бүсийн хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв байгуулагдсан | Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө | 100 | |
| 321 | | Иргэний эрүүл мэндийн боловсрол | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга | Байгууллагын цахим хуудас нь нийт 8701 дагагчтай бөгөөд тайлант хугацаанд иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх зорилгоор нийт 327 | Мэдээлэл сурталчилгааны хүртээмжт | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 80 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ыг дээшлүүлэх эд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 321 | хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | пост, 236 зураг, 68 видео, 64 рийл, 27текст, 16линк байршуулан 805,931 хандалт авсан. Иргэдийн хандалт өмнөх оны мөн үеэс 89,6%-р нэмэгдсэн байна. | эй байдал хангагдсан | | | |
| 130<br>131 | 205 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан ы 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14 | 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын өөрийн цахим хуудсаар болон фэйсбүүк хуудсанд холбогдох мэдээллүүдийг тухай бүр байршуулсан.<br>Шилэн дансанд нийт 171 мэдээлэл оруулахаас хугацаандаа мэдээлсэн 138, хугацаа хоцорч мэдээлэлсэн 1, хугацаа болоогүй 32 байна. | Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 95 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15 Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16 | бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;(Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар ) | | | | | |
| 79 | 139 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн | 3. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн | Хүний нөөцийн бүртгэл судалгааг Төрийн албаны “ХНУМТ” цахим системээр хөтлөн явуулж байна. Тайлант хугацаанд нийт 554 ажилтан цахим системд бүрэн бүртгэгдсэнээс 357 хүний мэдээлэл бүрэн баталгаажсан байна. Холбогдох мэдээ тайланг Орхон аймгийн төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. | Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна | ЗГ-ын тогтоол | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | | | | | |
| 147 | 235 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10 | 15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” | Тайлант хугацаанд иргэд, үйлчлүүлэгчээс нийт 119 хандалт ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хандалтын тохиолдлоор буурсан байна. Үүнээс:<br>Өргөдөл гомдлын төрөл:<br>- Талархал-16 (2024 онд 22)<br>- Хүсэлт- 18 (56)<br>- Санал- 6 (2)<br>- Гомдол- 36 (72)<br>Өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл: Харьцаа хандлагатай холбоотой-13 (2024 онд 32), Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд сэтгэл ханамжгүй-12 (26), Цаг товлох үйлчилгээ, хүлээгдэл чирэгдэлтэй холбоотой-6 (10), Эмнэлгийн дотоод орчны тохижилт, зохион байгуулалт-0 (2), Эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах-1 (0), Эрүүл мэндийн даатгалын өөрчлөлттэй холбоотой-2 (0), Албан бус төлбөр- 2 (3) агуулга бүхий өргөдөл гомдол байв. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%. Хариуцлага тооцсон ажилтан -3 | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 100 | |
| Хэрэгжилтийн дундаж хувь 85.3% (тодорхой үр дүнд хүрсэн) | | | | | | | | |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АЖИЛТАН А.БАЯРХҮҮ

ТАНИЛЦСАН:

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.НАРАН-ЭРДЭНЭ